



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/152

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2012 оны 289 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмч О.Дэлгэрсайхан нь ОХУ-ын Ард түмний найрамдлын их сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах болсонтой холбогдуулан дэмжлэг хүссэнийг харгалзан үзэж 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгийн 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2020 оны 06 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүд тайлагнахыг /О.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ